



X-XII/2021

Тархаасан: 2022 оны 2 дугаар сарын 15




## Манай улсаас 2021 оны 4 дүгээр улиралд БНСУ-д 154 иргэн цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан байна

Ажил эрхлэхээр хөдөлмөрийн гэрээгээр зуучлагдсан иргэдийн 147 (95.5%) нь эрэгтэй, 7 (4.5%) нь эмэгтэй байна.

Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад хөдөлмөр эрхлэхээр зуучлагдсан иргэдийн хамгийн их буюу 35.1 хувь нь 25-29 насныхан, 31.8 хувь нь 30-34 насныхан байгаа бол хамгийн бага буюу 1.3 хувь нь 40-44 насныхан байна.

**ЗУРАГ 1. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР ГАДААД УЛСАД ЗУУЧЛАГДСАН ИРГЭД, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар**



Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад хөдөлмөр эрхлэхээр зуучлагдсан иргэдийн 76 (49.4%) нь бүрэн дунд, 47 (30.5%) нь бакалаврын дээд, 20 (13.0%) нь тусгай мэргэжлийн дунд, 8 (5.2%) нь магистр, доктор, 3 (1.9%) дипломын дээд боловсролтой байна. Хөдөлмөрийн гэрээгээр зуучлагдсан 154 иргэн бүгд боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажил эрхлэхээр зуучлагджээ.

### Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөрийн гэрээгээр гадаад улсад зуучлагдсан иргэн нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зуучлагдсан хүмүүс юм.



**Эх үүсвэр:**

Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2022 оны 5 дугаар сарын 15

Нийгмийн статистикийн газрын  
дарга А.Амарбал  
Утас (976-51)-265543

Нийгмийн статистикийн газрын Өрхөд  
суурилсан судалгааны хэлтсийн статистикч  
Б.Лхагвасайхан  
Утас (976-51)-264797

